



МОНГОЛ УЛСЫН ИХ  
ХУРЛЫН ДАРГА САНДАГИЙН  
БЯМБАЦОГТ ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.05.06 № ЗГ-1/42

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуудал зөвшилцөх тухай

Австралийн Холбооны Улсын Сидней хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотноо Монгол Улсын Ерөнхий консулын газар тус тус нээн ажиллуулах тухай асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр хүргүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Н.УЧРАЛ

000264001256

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“3.1.ХЭЛЭЛЦСЭН нь: Австралийн Холбооны Улсын Сидней хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Австралийн Холбооны Улсын Сидней хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг хэлэлцэн дэмжээд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## ТАНИЛЦУУЛГА

Австралийн Холбооны Улсын Сидней хотод  
Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай

Монгол Улсын гадаад харилцаа 30 жилийн өмнөхтэй харьцуулахад өргөн хүрээнд идэвхтэй өрнөж, НҮБ-ын бүх гишүүн орнууд болон олон улсын бусад байгууллагууд, бүс нутгийн хамтын ажиллагааны механизмуудтай бүхий л түвшинд хамтын ажиллагаа өргөжин хөгжиж байна.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсаас хилийн чанадад 36 Элчин сайдын яам, 2 Байнгын төлөөлөгчийн газар, 9 Ерөнхий консулын газар, 4 Консулын газар буюу нийт 51 Дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна<sup>1</sup>.

Олон улсын харилцааны нөхцөл байдал улам бүр ээдрээтэй болж, дэлхийн дэг журам эрчимтэй хувьсан өөрчлөгдөж буй цаг үеийн шаардлагатай уялдуулан гадаад бодлого, үйл ажиллагаагаа улам бүр идэвхтэй, хурдтай явуулах хэрэгцээ, шаардлагатай тулгарч байна. Түүнчлэн дэлхийн зарим улс орнуудад монголчууд олноор төвлөрөн ажиллаж, амьдарч, цаашид улам бүр өсөн нэмэгдэх чиг хандлагыг харгалзан зарим улс орнуудад Дипломат төлөөлөгчийн газар сэргээх болон шинээр нээх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.2.17-д "Улс төр, эдийн засгийн харилцааны түвшин, ач холбогдол, тухайн улсад оршин суугаа монгол иргэд болон харилцан зорчиж байгаа иргэдийн тоо зэргийг харгалзан Дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгоно", 4.4.2.19-д "Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгжийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна" хэмээн тус тус заасан.

Төв Ази, Зүүн өмнөд Азийн орнууд, Зүүн өмнөд Азийн улсуудын хамтын нийгэмлэг (АСЕАН)-тэй харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хөгжүүлэх гадаад бодлогын зорилтын хүрээнд Монгол Улс 2024 онд Узбекистан Улсад Элчин сайдын яам шинээр нээж, Индонез Улс дахь Элчин сайдын яамны үйл ажиллагааг сэргээгээд байна.

Австралийн Холбооны Улсад оршин суугаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, консулын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагыг үндэслэн тус улсын Сидней хотод Ерөнхий консулын газар шинээр нээн ажиллуулах санал боловсруулав.

Өргөн хүрээтэй түншлэлийн харилцаатай Австралийн Холбооны Улсад 2025 оны байдлаар 24,650 гаруй монгол иргэн оршин сууж байгаа бөгөөд энэ нь хилийн чанадад оршин сууж буй монголчуудын тоогоор гуравдугаарт жагсах үзүүлэлт юм. Эдгээрээс 14784 нь Шинэ Өмнөд Уэльс муж, 2736 нь Викториа муж, 2662 нь Күинсланд муж, 1873 нь Баруун Австрали муж, 1010 нь Өмнөд Австрали муж, 1504 нь Австралийн Нийслэлийн бус нутаг, 60 нь Тасмани муж, 21 нь Хойд бүс нутагт тус

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 442 дугаар тогтоол

тус сурч, ажиллан амьдарч байна. Австралид оршин суугаа нийт монгол иргэдийн 60 гаруй хувь нь Шинэ Өмнөд Уэльс муж, тэр дундаа Сидней хотод байдаг бөгөөд Канберра дахь ЭСЯ-наас тус хотод улирал бүр, алслагдсан бусад муж, хотуудад тус бүр жилд 1 удаа явуулын консулын үйлчилгээ үзүүлдэг. Мөн цар тахлын хорио цээрийн дэглэм цуцлагдсан 2021 оны 7 сараас хойш тус улсыг зорих монгол иргэдийн тоо 5 дахин , оюутнуудын тоо 1,5 дахин /2021 онд 2777 байсан бол 2025 онд 5727 болсон/ нэмэгдэж, Канберра дахь ЭСЯ-наас иргэдэд үзүүлдэг консулын үйлчилгээний ачаалал нэмэгдсээр байна.

Монгол Улсын Засгийн газар, Австрали Улсын Засгийн газар хооронд 2022 онд “Ажиллах болон Амрах виз”-ийн тохиролцоог байгуулснаас хойш жил бүр 100 монгол залуус хөнгөлөлттэй нөхцөлөөр Австрали Улсад суралцах, аялах, хөдөлмөр эрхлэх нөхцөл бүрдсэн. Мөн хоёр улсын Засгийн газар хооронд “Агаарын харилцааны хэлэлцээр”, “Нийгмийн хамгааллын хэлэлцээр” байгуулахаар хамтарсан Ажлын хэсгүүд байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд ирэх жилүүдэд хэрэгжүүлэх өндөр, дээд түвшний айлчлалын үеэр хэлэлцээрүүдийг байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Эдгээр хэлэлцээрүүд байгуулагдсанаар Австралийг зорих монгол иргэдийн урсгал нэмэгдэх төлөвтэй байгаа болно.

Сидней хот орчмын мужуудад амьдарч буй монгол иргэдээс гадна Сиднейн нисэх буудлаар зорчиж буй болон гэрээний дагуу түр ажиллаж буй монгол иргэдэд консулын үйлчилгээ болон төрийн шаардлагатай бусад үйлчилгээг байнга, түргэн шуурхай үзүүлж, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг тусалцаа үзүүлэх шаардлага гарсаар байна.

Шинэ Өмнөд Уэльс нь Австралийн хамгийн том эдийн засагтай муж бөгөөд Австралийн ДНБ-ний 30 орчим хувь (700 орчим тэрбум ам.доллар)-ийг бүрдүүлдэг. Түүнчлэн Сидней хот Австрали Улсын төдийгүй дэлхийн санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чухал төвийн нэг юм. Австралийн аж үйлдвэрийн гол гол төлөөлөл, тухайлбал, Commonwealth Bank of Australia, Westpac Banking Corporation, Macquarie Group, Origin Energy, Qantas Airways, BlueScope Steel, CSL Limited зэрэг дэлхийн мөнгө санхүү, агаарын тээвэр, гангийн үйлдвэрлэл, биотехнологи, хөрөнгө оруулалтын чухал институтууд тус хотод байрлаж байна.

Австралийн Сидней хотноо Ерөнхий консулын газар нээн ажиллуулах нь тус монгол иргэдийн эрх ашгийг хамгаалахаас гадна Австралитай хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Манай Элчин сайд Сидней хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах боломжийн талаар Австралийн Гадаад хэрэг, худалдааны яамны Консулын болон хямралын үеийн удирдлага, зохион байгуулалт хариуцсан Тэргүүн туслах нарийн бичгийн даргатай уулзан тандаж ярилцахад айлын тал татгалзах зүйлгүй гэдгээ илэрхийлж, монголын талаас Консулын тойргийн хамрах хүрээг тодорхойлон ноот бичиг ирүүлсний дараа тухайн мужийн захиргаанд танилцуулдаг журамтайг айлын талаас мэдээлсэн болно.

**2026 ОНД ШИНЭЭР НЭЭГДЭХ ДТГ-ЫН ТӨСӨВ**  
/урьдчилсан тооцоолол/

| №    | Зардлын зүйл  | Төсөв /төгрөгөөр/    | Төсөв /ам.доллараар/ |
|------|---|----------------------|----------------------|
| 1    | <b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>                                      | <b>2,270,948,400</b> | <b>597,618</b>       |
|      | <b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>                                     | <b>2,270,948,400</b> | <b>597,618</b>       |
| 2    | <b>БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | <b>2,270,948,400</b> | <b>597,618</b>       |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил /АО-ын НДШ/                | 417,878,400          | 109,968              |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                     | 741,000,000          | 195,000              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                              | 43,320,000           | 11,400               |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                             | 121,600,000          | 32,000               |
| 2107 | Томилолт, зочны зардал  | 228,000,000          | 60,000               |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж | 453,150,000          | 119,250              |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 266,000,000          | 70,000               |
|      | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                         | <b>2,270,948,400</b> | <b>597,618</b>       |
|      | Төсвөөс санхүүжих   | <b>2,270,948,400</b> | <b>597,618</b>       |

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 11 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“3.2.ХЭЛЭЛЦСЭН нь: Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай асуудлыг хэлэлцэн дэмжээд, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

## ТАНИЛЦУУЛГА

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотод Ерөнхий консулын газар нээн ажиллуулах тухай

Монгол Улс гадаад харилцаагаа сүүлийн 30 жилд идэвхтэй хөгжүүлж, НҮБ-ын бүх гишүүн улстай дипломат харилцаа тогтоон олон улсын болон бүс нутгийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бүх түвшинд хөгжүүлж байна. Өнөөдрийн байдлаар хилийн чанадад 36 Элчин сайдын яам, 2 Байнгын төлөөлөгчийн газар, 9 Ерөнхий консулын газар, 4 Консулын газар буюу нийт 51 дипломат төлөөлөгчийн газар үйл ажиллагаа явуулж байна.

Олон улсын харилцааны орчинд гарч буй өөрчлөлт, гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн тоо тогтмол өсч байгаатай уялдуулан дипломат төлөөлөгчийн газруудын байршил, бүтэц, орон тоог оновчтой болгох, иргэдэд үзүүлэх консулын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах шаардлага тулгарч байна. Монгол Улсын Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дээрх зорилт тусгасан бөгөөд энэ хүрээнд 2024 онд Узбекистан Улсад Элчин сайдын яам шинээр нээж, Индонез Улс дахь Элчин сайдын яамны үйл ажиллагааг сэргээсэн болно.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад оршин суугаа монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах, консулын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагыг үндэслэн Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Франкфурт хотод Ерөнхий консулын газар шинээр нээн ажиллуулах санал боловсруулав.

Стратегийн түншлэлийн харилцаатай Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад 2025 оны байдлаар 8962 гаруй монгол иргэн оршин сууж байгаагаас 5247 орчим нь Франкфурт хотын ойролцоох 5 мужид амьдарч байна. Тухайлбал, Баварид 1236, Умард Райн Вестфаленд 2668, Баден Вюртембергт 868, Хессенд 475 монгол иргэд ажиллаж, амьдарч байна. Эдгээр мужууд Берлинээс нэг талдаа 650-700 километр зайд, алслагдмал оршдог тул Берлин дэх Элчин сайдаас яамнаас жилд дөрвөөс доошгүй удаа очиж явуулын консулын үйлчилгээ үзүүлдэг ч жилээс жилд ирж буй иргэдийн тоо нэмэгдсээр байгаа тул иргэдээс явуулын үйлчилгээг сар бүр авах хүсэлт гаргаж байна.

Улаанбаатар-Франкфурт чиглэлд “МИАТ” компанийн тогтмол нислэгээр зорчих манай иргэдийн тоо сүүлийн жилүүдэд байнга өсөж байна. 2023 онд 35000 орчим иргэд зорчиж байсан бол 2024 онд 42500 орчим болж нэмэгдсэн.

Түүнчлэн Европын улсуудад суугаа манай ДТГ-уудын ихэнх дипломат ачаа МИАТ-ын нислэгээр Франкфуртын олон улсын нисэх онгоцны буудлаар дамжин өнгөрдөг бөгөөд дипломат ачааг буух үед нь саадгүй нэвтрүүлэх, холбогдох зохицуулалтыг хангах үүднээс Берлин дэх ЭСЯ-ны Консулын хэлтсийн ажилтан томилолтоор ажилладаг.

Манай оюутнууд зуны амралтаараа Германы баруун мужуудад жимс, жимсгэнийн талбайд ажиллах нь тогтмолжоод байна. Тэдний эрх ашиг хөндөгдөхөд Берлин дэх Элчин сайдын яамнаас тухай бүр яаралтай очиж үйлчилгээ үзүүлэх боломжгүй байдаг нь хүндрэл үүсгэж буй. Тухайлбал 2024 онд 320 оюутан ирсэн ба маргаантай асуудал үүссэний улмаас 75 оюутан гэрээгээ эрт цуцлан нутаг буцсан. Өнгөрсөн онд 350 орчим оюутан ирж ажилласан байна.

Франкфурт хот орчмын мужуудад амьдарч буй монгол иргэдээс гадна Франкфуртын нисэх буудлаар зорчиж буй болон гэрээний дагуу түр ажиллаж буй монгол иргэдэд консулын үйлчилгээ болон төрийн шаардлагатай бусад үйлчилгээг байнга, түргэн шуурхай үзүүлж, тэдний хууль ёсны эрх ашгийг хамгаалах, дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлага гарсаар байна.

Франкфурт хот ХБНГУ-ын санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтын чухал төвийн нэг юм. Германы аж үйлдвэрийн гол гол төлөөлөл, тухайлбал, Мерседес Бенц, Siemens болон жижиг, дунд үйлдвэрлэлийн аж ахуйн нэгжүүд ихэвчлэн "хуучин" баруун бүс нутагт буюу Франкфурт хотоос холгүй тархсан байрлалтай байдаг. Түүнээс гадна тус хот Германы төдийгүй Европын Холбооны санхүү, хөрөнгийн биржийн гол төв гэж нэрлэгддэг бөгөөд Европын Төв банк, Дойче банк зэрэг дэлхийн мөнгө санхүү, хөрөнгө оруулалтын чухал институтүүд тус хотод байрлаж байна.

Манай Элчин сайд Франкфурт хотод Монгол Улсын Ерөнхий консулын газар нээн ажиллуулах боломжийн талаар ХБНГУ-ын Гадаад хэргийн яамны Ёслолын хэлтсийн дэд захиралтай уулзан тандаж ярилцахад айлын тал татгалзах зүйлгүй гэдгээ илэрхийлж, монголын талаас Консулын тойргийн хамрах хүрээг тодорхойлон ноот бичиг ирүүлсний дараа тухайн мужийн захиргаанд танилцуулдаг журамтайг айлын талаас мэдээлсэн болно.

---oOo---

2026 ОНД ШИНЭЭР НЭЭГДЭХ ДТГ-ЫН ТӨСӨВ  
/урьдчилсан тооцоолол/

| №    | Зардлын зүйл  | Төсөв /төгрөгөөр/    | Төсөв /ам.доллараар/ |
|------|---|----------------------|----------------------|
| 1    | <b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>                                      | <b>2,304,768,400</b> | <b>606,518</b>       |
|      | <b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>                                     | <b>2,304,768,400</b> | <b>606,518</b>       |
| 2    | <b>БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | <b>2,304,768,400</b> | <b>606,518</b>       |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил /АО-ын НДШ/                | 417,878,400          | 109,968              |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                     | 741,000,000          | 195,000              |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                              | 43,320,000           | 11,400               |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                             | 121,600,000          | 32,000               |
| 2107 | Томилолт, зочны зардал  | 228,000,000          | 60,000               |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж | 479,370,000          | 126,150              |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                               | 273,600,000          | 72,000               |
|      | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                         | <b>2,304,768,400</b> | <b>606,518</b>       |
|      | Төсвөөс санхүүжих   | <b>2,304,768,400</b> | <b>606,518</b>       |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ КОНСУЛЫН ГАЗАР НЭЭН АЖИЛЛУУЛАХ

АСУУДЛААРХ АЖЛЫН ХЭСЭГ

| <b>Д/Д</b> | <b>Овог, нэр</b> | <b>Албан тушаал</b>  | <b>Утасны дугаар</b> |
|------------|------------------|--|----------------------|
| 1.         | Г.Бямбасүрэн     | Гадаад харилцааны яамны<br>Бодлогын газрын захирал   | 94075507             |
| 2.         | Г.Баттулга       | ГХЯ-ны Америк, Ойрхи дорнод<br>далайн орнуудын газрын захирлын<br>албан үүргийг түр орлон гүйцэтгэгч         | 94249419             |
| 3.         | Г.Баттунгалаг    | ГХЯ-ны Европ, Африкийн газрын<br>захирал   | 99117546             |
| 4.         | Т.Бат-Орших      | ГХЯ-ны Консулын газрын дэд<br>захирал  | 89170066             |
| 5.         | Б.Нямдаваг       | ГХЯ-ны Төрийн захиргаа, хүний<br>нөөцийн удирдлагын газрын<br>захирлын албан үүргийг түр орлон<br>гүйцэтгэгч | 88113678             |